

СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.04 №02 (02)

ҮЙЛ ЯВДАЛ

ЦЭРГИЙН ШТАБЫНХАН ЦАХИМ ЦУГЛАРАЛТААР...



Аймаг, нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга нарын цугларалтыг өчигдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа. "Батлан хамгаалах зорилгыг хэрэгжүүлэхэд орон нутаг дахь манлайлал" сэдэвт тус цугларалтын эхэнд БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба БХЯ-наас 2020 онд хийж хэрэгжүүлсэн томоохон ажлууд, 2021 оны зорилго, зорилт, цаашдын төлөвлөлтийн талаар танилцуулга хийж, мэдээлэл өгөв. Үргэлжлүүлэн Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, олон улсын харилцаа судлаач, профессор Д.Баярхүү нар "Батлан хамгаалахын нэгдмэл хяналт", "ОХУ-ын геополитикийн нүдээр Монгол Улс Аюулгүй байдал, Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаанд баримтлах үндсэн асуудал" сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн юм. Мөн "Цэргийн штабуудад тулгамдаж буй асуудал, сайжруулах арга зам, санал дүгнэлт" сэдвээр Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа

М.Дэлгэрсайхан мэдээлэл хийв. Нэг өдрийн турш үргэлжилсэн энэхүү цугларалтаар удирдах ажилтны болон хувь хүний манлайлал, байгууллагын соёл, цэргийн дайчилгааны тогтолцооны шинэчлэл, дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад зохион байгуулах үеийн онцлог зэрэг чухал ач холбогдол бүхий сэдвүүдийг хөндсөн юм. Энэ ч утгаараа орон нутагт Батлан хамгаалах бодлого, зорилгыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, харилцан шинэ мэдээ, мэдээлэл солилцсон ач холбогдол өндөртэй сургалт болж өндөрлөлөө.

Цугларалтын төгсгөлд Өвөрхангай, Дорнод, Орхон, Төв аймаг болон Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб 2020 оны үйл ажиллагаагаараа тэргүүлснийг БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Д.Ганхуяг онцлоод цугларалтад оролцсон бүрэлдэхүүнд үүрэг чиглэл өгч, ажлын амжилт хүслээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ...



ТАВДУГААР САРААС АГААРЫН ХИЛЭЭ НЭЭНЭ

Засгийн газрын өчигдөрийн ээлжит хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Тодруулбал, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн өгсөн чиглэлийн дагуу ирэх 5 дугаар сарын 1-ний өдрөөс Буянт-Ухаа боомтыг нээж, олон улсын зорчигч тээврийн хөдөлгөөний хязгаарыг цуцлахаар төлөвлөж байна. Энэ үүднээс хилийн хяналтын байгууллагын албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах, халдварын сэжигтэй хүнийг боомтод түр тусгаарлах өрөө, зорчигч, хилийн албаны ажилтныг заагласан шилэн хаалт, хүн хоорондын зай барих тэмдэглэгээ, туузан хаалт хийх зэргээр халдвар хамгааллын дэглэм мөрдөх бүх бэлтгэлээ хангаж эхэлжээ. Хил нээх, нээсний дараа дагаж мөрдөх дүрэм, журмыг батлах, цахим визаны нэгдсэн систем боловсруулж 2021 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс нэвтрүүлнэ. Цаашид эрсдэлийг харгалзан бусад боомтыг нээх эсэхийг тухай бүрт нь шийдвэрлэх ажээ.

МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

❖ Монгол, Хятадын хилийн боомтод тээвэр хийж байгаа жолооч нарыг энэ сард багтаан цар тахлын эсрэг дархлаажуулалтад хамруулахаар болов. Ингэснээр нүүрс, бусад бараа бүтээгдэхүүний экспортын хэмжээ хэвийн түвшинд хүрэх, цаашид өсөн нэмэгдэхэд чухал нэмэртэй гэж үзлээ.

❖ Хуримтлалын нэгдсэн сангийн тухай хуулийн төсөл боловсруулахыг сайд нарт даалгалаа. Сан байгуулснаар байгалийн баялгийг иргэн бүр тэгш хүртэх боломж бүрдэнэ. Тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжинэ, ипотек, хөрөнгийн зах зээл, арилжааны банкинд байршуулах, боловсролын зээл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг энэ сангаас авах зэрэг ач холбогдолтой хэмээн үзэж байна.

❖ "Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластер"-ын Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна. Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутагт кластер байгуулахаар төлөвлөж байна. Энд биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологи зэрэг тэргүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан судалгааны төв байрлах бөгөөд 3,000 гаруй эрдэмтэн судлаач, ажилтан ажиллах юм.

❖ Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө"-г баталлаа. Төв цэвэрлэх байгууламжид ирж байгаа хаягдал усны эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж, мэдээллийн сан бий болгох, үйлдвэрүүдэд хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламж, тоног төхөөрөмж суурилуулахад дэмжлэг үзүүлэх, арьс, ширний үйлдвэрүүдийг нүүлгэх хүртэл "Харгиа" цэвэрлэх байгууламжийг хэвийн ажиллуулах, усыг дахин ашиглах, хяналт, зохицуулалттай холбоотой хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг ажил хийхээр төлөвлөгөөнд тусгажээ.

❖ "Монгол соёл, Монгол баялаг" стратеги төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхаар болов. Соёлын яам төрмөл авьяас билгийг эрх зүй, санхүү, дэд бүтэц, техник, технологитой хослуулан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, монгол хүн, монгол бүтээлийг дэлхий хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх боломжийг бүрдүүлэх зорилгоор төслийг боловсруулжээ.

ХУРАНДАА НАР ЧУУЛЛАА

Монгол Улсад цэргийн цол бий болгож, "Хурандаа" хэмээх цол олгож эхэлсний 85 жилийн ой энэ жил тохиож байгаа билээ. Тус ойг тохиолдуулан "Монгол хурандаа" нийгэмлэг төрийн бус байгууллагаас "Монгол Улсын цэргийн цолны үүсэл замнал-Хурандаа цолтон" онол практикийн бага хурлыг энэ сарын 2-ны өдөр зохион байгууллаа. Тус нийгэмлэгийн дэд тэргүүн, профессор, хурандаа

зэрэг сэдвээр тус нийгэмлэгийн УЗ-ийн гишүүн, Хил хамгаалах байгууллагын хурандаа нарын Салбар зөвлөлийн дарга, магистр, хурандаа Д.Мөнхбат, ТЕГ-ын ажилтан, судлаач, хошууч Н.Батболд, доктор /Ph.D./, цагдаагийн хурандаа Х.Түвшинжаргал, онол практикийн бага хурлаас судлаач, бэлтгэл дэд хурандаа М.Бямбарагчаа нарын хүмүүс нийт долоон хавсралт илтгэлийг хэлэлцүүлж, сонирхолтой яриа



Д.Баярхүү хурлыг нээж уг хэлсний дараа мөн нийгэмлэгийн ерөнхий менежер, магистр, хурандаа Л.Амарсайхан "Монгол Улсын цэргийн цолны үүсэл замнал-Хурандаа цолтон" сэдвээр үндсэн илтгэлийг хэлэлцүүлсэн юм. Улмаар "Эх орны тусгаар тогтнол, эх орон, газар нутгийн төлөө тэмцэж байсан эрэлхэг хурандаа нарын түүхэн замнал", "Улсын аюулгүй байдлыг хангахад хүчин зүтгэсэн хурандаа нарын түүхэн замнал, тэдгээрийн цол, дүрэмт хувцасны онцлог", "Хүн ардын амар тайван амьдралын төлөө зүтгэсэн хурандаа нарын дайчин замнал", "Монголын утга зохиол, урлагт хурандаа цолтны нийтлэг дүр төрх, баатарлаг, хөдөлмөрч зан чанарыг тодорхойлсон нь"

өрнүүлэв. Хурандаа хэмээх эрхэм цолны тухайд түүх сөхвөл, БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид ба Ардын сайд нарын зөвлөлийн хамтарсан хуралдааны тогтоолоор МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнд олгох цэргийн алдар цолыг бий болгосон түүхтэй. Тэгвэл тус тогтоолыг үндэслэсэн ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн Жанжны 1936 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 6 дугаар тушаалаар ЦЯЯ-ны хоёрдугаар хэлтсийн дарга Зундуйн Жанцан, мөн яамны хэлтсийн дарга Дооровын Дэшзэвэг нарт хурандаа цолыг олгосноор эл цолны эхлэл тавигджээ.

(Үргэлжлэл нь арын нүүрт)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-8°C	-25°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39°C	26°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
18°C	2°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,849.87	2,851.0
EUR	3,430.0	3,445.0
CNY	440.0	441.5
RUB	37.80	39.50
JPY	26.37	26.89
KRW	2.46	2.59

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	32
НИЙТ БҮРТГЭГДСЭН	3032
ЭДГЭРСЭН	2360
НАС БАРСАН	6

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	9
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	181
ЭДГЭРСЭН	763

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.04. /ПҮРЭВ ГАРАГ/
ХАВРЫН ТЭРГҮҮН ЦАГААН БАР САРЫН НАЙМАН ЦАГААН ЦАГААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулвал: **Өвчин ирнэ.**

Наран ургах, шингэх: **07.27-18.41**

Барилдлага: **Хүчин төгсөх**

Шүтэн барилдлага: **Сансар**


Суудал: **Хий**

Аргын тооллын 3 дугаар сарын 4, Бархасвадь гараг, Билгийн тооллын 21, хонгорцог одтой, цагаагчин гахай өдөр. Өдрийн наран 7 цаг 27 минутад мандан 18 цаг 41 минутад жаргана. Тухайн өдөр туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд зөрөг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсон урагш мөрөө гаргавал зохистой. Үс шийнээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЦАХИМ ШУУДАНД

"CDIO" СТАНДАРТ, АРГА ЗҮЙН АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ҮБХИС



БШУЯ-аас баримталж буй Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд "Үрдүнд суурилсан боловсрол" – "CDIO стандарт, арга зүйн ахисан түвшний сургалт"-ыг Багшийн хөгжлийн төв өнгөрсөн сарын 22-ны өдрөөс энэ сарын 1-ний өдрүүдэд профессор багш нарт зориулан зохион байгуулав. Сургалтад CDIO стандарт, арга зүйн анхан шатны сургалтад хамрагдсан ҮБХИС-ийн харьяаллын академи, дээд сургууль, коллеж, төв, тэнхимийг төлөөлж, нийт 23 багш

оролцсон юм. Сургалтаар CDIO стандарт, арга зүйн хүрээнд ирээдүйн төгсөгчдийн зураглал гаргаж, салбар дундын төсөл боловсруулах аргачлалд суралцаж, сургалтын онцлогт тохирсон орчныг загварчлаж, хөтөлбөрт сайжруулалт хийх арга зүйд суралцахын зэрэгцээ Microsoft teams программ, Mentiimeter, Padlet апплейкшнуудыг ашиглаж багшлах арга зүйдээ нэвтрүүлэх боломжийг олгосон ач холбогдолтой сургалт болж өндөрлөлөө.

Ахмад Б.НАНДИНЦЭЦЭГ

ЯВГАН МАРШ ҮЙЛДЭВ

234 дүгээр анги

*Энэ оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу салбарын жигдрэлтийг хангах хүрээнд офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид тодорхой маршрутын дагуу 30 километрийн явган марш үйлдлээ. Түүнчлэн алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэхээр хэд хэдэн уралдаан зохион байгуулсан бөгөөд цасны сумо тэмцээний эхний байруудад дэд ахлагч А.Энхбаяр, ахлагч Г.Пүрэвням, дэд ахлагч Б.Ууганбаяр нар шалгарсан юм.

*Булган аймгийн Онцгой байдлын газрын дарга, Аймгийн Онцгой комиссын шуурхай штабын дарга, хурандаа Ш.Баасандорж коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг дэмжих ангийн бие бүрэлдэхүүнд амны хаалт, халуун хэмжигч, гар ариутгагч зэргийг хүлээлгэн өглөө.

Ч.ОЮУНЧИМЭГ

СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦЫГ ШАЛГАЛАА

065 дугаар анги

*Ангийн Сургалт, соёл хүмүүжлийн албанаас ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч даргын албан даалгаварыг үндэслэн харьяа байгууламж, тусгай ротуудын сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн явцтай танилцаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шалган туслах ажил явууллаа. Шалгалтыг "Ковид-19" цар тахлын тархалттай холбоотойгоор цахим хэлбэрээр зохион байгуулсан юм. Тус шалгалтаар салбарын захирагчийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах тушаал, заах арга зүйн зөвлөлийн гишүүдийг томилсон тушаал, ажил үүргийн хуваарь төлөвлөгөө, сургалт, сэтгэл зүйн хангалтын мэдээ ирүүлсэн байдал, хичээлийн хуваарь, хичээлийн хөтөлбөр, журнал хөтөлөлт, цэргийн алба хаагчийн хичээлийн дэвтэрт буусан байдал гэсэн үзүүлэлтүүдээр шалгаж үнэлэв.

*Мөн тус ангийн Эрүүл мэндийн төвийн хамт олон ЗХЖШ-ын Удирдлагын шуурхай бүлгийн тандалт судалгааны багтай хамтран коронавирусын халдварын тандалт хийх, урьдчилан сэргийлэх зорилгоор алба хаагчдаа PCR шинжилгээнд бүрэн хамрууллаа. Шинжилгээний үеэр ажилтан, алба хаагчдын биеийн дулааныг хэмжиж, хүн хоорондын зай барьж, халдвар хамгааллын дэглэмийг нарийн чанд баримтлан ажиллав.

Ахмад З.АНХБАЯР

СЭТГЭЛИЙН ӨГЛӨГ

340 дүгээр анги

Ангийн бие бүрэлдэхүүн нийгмийн хариуцлагын хүрээнд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн зэвсгийн албаны офицер, хошууч Б.Эрдэнэбаярт 1,190,500 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлэв. Хошууч Б.Эрдэнэбаяр нь СМЛ буюу миелоид эсийн гаралтай цагаан эсийн арга хавдар гэх оноштойгоор Турк

Улсын Мемориал эмнэлэгт 300.000.000 төгрөгөөр эмчлүүлэх болсон тул "Амьдрал бэлэглэх" сэтгэлийн хандив өрнөж байгаа юм. Тиймээс далайд дусал нэмрийн адилаар Зэвсэгт хүчний анги, салбаруудыг энэхүү аянд идэвх санаачлагатай хамрагдахыг Зэвсэгт хүчний 340 дугаар ангийн хамт олон уриалж байна.

Дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН

ХУРАНДАА НАР ЧУУЛЛАА

(Түрүүч нь тэргүүн нүүрэнд)

Энэхүү түүхэн цаг үеэс улбаалан уг цолыг ЦЯЯ-ны яамны сайд бөгөөд Бүх цэргийн жанжин, Цэрэг ба Аюулаас хамгаалах яамны сайд, АЦХЭЯ-ны сайд, АА-ийн командлагч, ДЯЯ-ны сайд, БХЯ-ны сайд, НАХЯ-ны сайд, Хууль, зүй дотоод хэргийн сайд, УАБХЕГ-ын дарга, ЦЕГ-ын дарга, Хорих байгууллагуудыг удирдах газрын дарга, ОБЕГ-ын дарга нарын шийдвэрээр тус тус олгож байсан юм.

Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 41 дүгээр зарлигаар батлагдсан "Цэргийн цол олгох журам"-ын дагуу 1999 оны 3 дугаар сарын 20-ноос эхлэн ЗХЖШ-ын даргын тушаалаар олгож байхаар шийдвэрлэжээ. Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын цэргийн алба хаагчдад хурандаа



цолыг 1936, цагдаагийн алба хаагчдад 1945, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчдад 1964, Онцгой байдлын албаны алба хаагчдад 1971 оноос эхлэн

тус тус олгосон байна. Дашрамд сонирхуулахад энэхүү цолыг тэртээх 1509 онд Францын Легионы армид анх хэрэглэж байсан түүхтэй.

ТАНЫ СОНОРТ

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, штабын ажилтны сонгон шалгаруулалтыг 2021 оны 4 дүгээр сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулав.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр

ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1.Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;

сертификатын хуулбар; 5.Сүүлийн 3 сарын дотор авахуулсан 4x6 хэмжээтэй цээж зураг 2 хувь. 6.Товч судалгаа

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг ЭДЦХАХ-ийн psod@mil.gov.mn цахим хаягаар ирүүлэх болон тус хэлтсийн ахлах мэргэжилтан, дэд хурандаа

Анги	Албан тушаал	Цол	Овог, нэр	Нас	Боловсрол, цэргийн мэргэжил	Анги, байгууллагад ажилласан байдал	ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал

батлагдсан "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам" болон НҮБ-ын цэргийн ажиглагч, штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх

2.Ажил байдлын тодорхойлолт
3.Жолооны үнэмлэхийн хуулбар;
4.Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн

И.Эрдэнэсүрэн /3675, 92115982/-тэй холбогдон тодруулж болно.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

ГАДААД МЭДЭЭ



"ЛОЯЛ ВИНГМЭН"-НИЙ АНХНЫ НИСЛЭГ АМЖИЛТАЙ

Дэлхийн ихэнх улс орнууд батлан хамгаалах салбарынхаа нөөц бололцоог нэмэгдүүлэх, илүү аюулгүй арга замыг эрэлхийлж байгаатай холбогдуулан бие даасан, илүү найдвартай технологид хөрөнгө оруулах хандлага бий болсоор байна. Үүний нэг жишээ нь АНУ-ын Агаарын цэргийн хүчний "Скайборг" онгоцны загварт суурилсан нисгэгчгүй сөнөөгч онгоцыг Австралийн Хатан хааны нисэх хүчин өөрсдийн технологид нутагшуулан, хиймэл оюун ухаанд суурилсан "Лоял Вингмэн" онгоцыг бүтээх төслийг эхлүүлсэн бөгөөд өчигдөр тус онгоцны туршилтын нислэгийг амжилттай гүйцэтгэжээ. Агаарын цэргийн дэд маршал Кэт Робертс хэлэхдээ, "Энэхүү төсөл нь манай орны Агаарын цэргийн хүчин болон Австралийн "Боинг" компанийн хувьд томоохон алхам болж чадсанаас гадна ирээдүйд Зэвсэгт хүчинд ашиглагдах илүү ухаалаг техник, технологийг бий болгоход түлэх үзүүлнэ" гэв.



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонини редакцал бэлтгэв.

*Зар, рекламныг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029